



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№36 /480/

2023.02.28

Цаг үе, үйл явдал


АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ЭХЛҮҮЛЭВ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2023 оны 02 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд Арабын Нэгдсэн Эмират Улсад ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Төрийн сайд Мохаммед Ахмед Аль-Буардитай хоёр талын уулзалт хийв. Уулзалтаар талууд хоёр орны дипломат харилцааны хүрээнд худалдаа, эдийн засаг, аялал жуулчлал эрчимтэй хөгжиж ирсэнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, цаашид найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, түүнчлэн батлан хамгаалах салбарт хамтран ажиллах бүрэн боломжтой гэдэгт харилцан санал нэгдсэн юм.

Уулзалтын төгсгөлд сайд нар Монгол Улсын Батлан хамгаалах яам, Арабын Нэгдсэн Эмират Улсын Батлан хамгаалах яамд хоорондын батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т гарын үсэг зурлаа.

"Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулснаар Арабын Нэгдсэн Эмират Улстай батлан хамгаалах салбарт хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдэж, цэргийн хамтын ажиллагааг албан ёсоор эхлүүлснээр Монгол Улсын Батлан хамгаалах



яам дэлхийн 39 дэх улстай цэргийн дипломат харилцаа тогтоосон түүхэн үйл явдал болсон юм.

Мөн тус улсад хийсэн айлчлалын үеэр сайд Г.Сайханбаяр Абу Даби хотноо зохион байгуулагдсан Батлан хамгаалахын олон улсын бага хуралд хүндэт зочноор оролцов. Энэхүү олон улсын бага хуралд дэлхийн 80 гаруй улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн, батлан хамгаалах судлал, аюулгүй байдал, аж үйлдвэрийн чиглэлээр үйл

ажиллагаа явуулдаг 24 олон улсын байгууллагын 2800 орчим албаныхан, эрдэмтэн, судлаачид оролцсон ач холбогдолтой хурал болж өндөрлөлөө.

Хурлын төлөөлөгчид технологийн хөгжлийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, орчин цагийн цэргийн ажиллагаа, дайнд технологийн дэвшлийг өргөнөөр хэрэглэхийн сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны

талаар санал бодлоо солилцсон юм.

Түүнчлэн айлчлалын бүрэлдэхүүн 30 дахь жилдээ зохион зохион байгуулагдсан "IDEX and NAVDEX-2023" батлан хамгаалахын зэвсэглэл, техникийн үзэсгэлэнг үзэж сонирхсон юм.

Улмаар дэлхийн бусад улс орнуудын зэвсэгт хүчний хөгжил, зэвсэглэл хүчинтэй танилцаж Монгол Улсын Зэвсэгт хүчинд шаардлагатай зэвсэглэл, тоног төхөөрөмжийг судлав. Уг үзэсгэлэнд дэлхийн 65

орны батлан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1350 орчим үйлдвэрлэгчид, 130.000 гаруй зочид, төлөөлөгч оролцсон томоохон арга хэмжээ зохион байгуулагдав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын Арабын Нэгдсэн Эмират Улсад хийсэн энэхүү айлчлал нь Монгол Улсын батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд түүхийн нэгэн шинэ хуудсыг нээсэн, өндөр ач холбогдолтой айлчлал боллоо.



САР ШИНИЙН ЗОЛГОЛТ ХИЙЛЭЭ

БХЯ-ны удирдлага бие бүрэлдэхүүн уламжлал ёсоор билгийн тооллын XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх усан туулай жилийн сар шинийн золголт болон Бүх цэргийн их хар сүлдээ тайх ёслол хийж, хүндэтгэл үзүүлээ.

Энэ удаагийн ёслол шинийн наймны билэгт сайн өдөр тохиосноороо онцлог байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд

Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганямба тэргүүтэй салбарын удирдлагууд, төрлийн цэргийн командлагчид, БХЯ-ны харьяа байгууллагуудын дарга нар түүнчлэн БХЯ-ны нийт бие бүрэлдэхүүн оролцлоо.

Энэ үеэр Монгол ардын уртын дуу "Эртний сайхан", морин хуурын татлага эгшиглүүлж, бурхан шүтээндээ мөргөн туулай жилийн ажил үйлсээ даатгалаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	-18

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,526	3,530
EUR	3,756	3,770
CNY	507.50	509.50
RUB	45.30	46
JPY	26.30	26.70
KRW	2.70	2.72

ЗУРХАЙ



ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.36-18.34

Барилдлага:

Хүчин төгсөх
ШҮТЭН БАРИЛДАГА:
Авахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол газлан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 679,863,391

Эдгэрсэн

Нийт: 652,708,020

Нас барсан

Нийт: 6,799,564

Цахим шууданд

НИСГЭГЧ, ИНЖЕНЕР ТЕХНИКЧДИЙН УР ЧАДВАР НЭМЭГДСЭЭР БАЙНА



Байлдааны сөнөөгч онгоцны эскадриль, байлдааны сөнөөгч онгоцны засварын төв, нислэгийн үйлчилгээний батальоны бие бүрэлдэхүүн нислэгийн урьдчилсан бэлтгэлийг хангаж, байлдааны сөнөөгч онгоцны нисгэгч, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн нислэг эрхэлсэн нэгдүгээр орлогч хошууч Б.Батболдын удирдлагын дор ахмад Х.Энх-Амар, ахлах дэслэгч Б.Цолмонбаатар, ахлах дэслэгч Б.Хэрлэн зэрэг нисгэгчид дадлагын нислэгийг амжилттай гүйцэтгэлээ.

Сургууль дадлагын нислэгээр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн байцаагч-нисгэгч ахлах дэслэгч Б.Цолмонбаатар, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байлдааны сөнөөгч онгоцны эскадрилийн ахлах нисгэгч-штурман ахмад Х.Энх-Амар нар бие даасан нислэг, мөн байлдааны сөнөөгч онгоцны эскадрилийн их бие хөдөлгүүрийн механикч дэд ахлагч Б.Алтаншагай, байлдааны сөнөөгч онгоцны засварын төвийн техникч ахлагч Б.Мөнх-Эрдэнэ нар бие даасан

нислэгийн урьдчилсан бэлтгэлийг гүйцэтгэж, нислэг, нислэгийн аюулгүй байдлыг ханган, нисгэгч инженер техникийн бүрэлдэхүүн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлээ.

Уг сургууль дадлагын нислэгийг цаг уурын эрс хүйтэн, үзэгдэх орчин хязгаарлагдмал, бүрэнхий үеийн нөхцөл байдалд үргэлжлүүлсэн нь нисгэгчдийн нислэгийн ур чадварыг сорьсон, бататгасан онцлог ач холбогдолтой байлаа.

БИДНИЙ ДЭМ БУСДАД ИНЭЭМСЭГЛЭЛ



Завхан аймгийн 100 жилийн ой, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Завхан аймгийн Цагдаагийн газар, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Бидний дэм бусдад инээмсэглэл" сэдэвт арга хэмжээг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Завхан аймгийн Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Отгон тэргүүтэй сумдын ард иргэдийг хамруулж Зэвсэгт хүчнийг ард иргэдэд

сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийж мэдээ мэдээлэл өгсөн юм.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 325 дугаар анги Завхан аймгийн Цагдаагийн газрын амьд хөгжмийн хамтлагтай хамтран урлагийн тоглолтыг зохион байгуулж, олсон орлогоо тусламж шаардлагатай иргэд болон айл өрхүүдэд хүлээлгэн өглөө.

“ТАЛЫН НААДААН” ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Сар шинийн баярыг тохиолдуулан үндэсний өв соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Талын наадаан” тэмцээнийг ангийн бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулаа. Тэмцээнд найман баг

авьяас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт ахлах дэслэгч М.Хосбаяр багийн ахлагчтай “Шинийн нэгэн” баг, дэд байрт дэслэгч Б.Дашням ахлагчтай “Талын салхи” баг тус тус шалгарч бусад нөхдөө манлайллаа.

Ахмад Х.ӨСӨХБЯАР



Эерэг

АХМАДУУДАА САР САР ШИНИЙН МЭНД ДЭВШҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

XVII жарны “Үзэсгэлэнт болгогч” хэмээх харагчин туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан тус ангиас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчдадаа хүндэтгэл үзүүлж, сар шинийн мэнд дэвшүүлэн, урт удаан наслахыг хүсэн ерөөв.



АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙН ЦОЛ ОЛГОЛОО



ангийн захирагч хурандаа Э.Батсайхан “Цэргийн цол нэмэх нь алба хаагчдын эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага, мэргэшсэн байдлыг илэрхийлдэг” гэдгийг онцлоод нийт бие бүрэлдэхүүнд ажлын хариуцлагаа нэмэгдүүлэх, хариуцсан албандаа эзний ёсоор хандах, цаашид улам хичээж, ажиллахыг захисан юм.

Хошууч А.БААСАНПҮРЭВ



Зэвсэгт хүчний 337 дугаар анги Билгийн тооллын XVII жарны харагчин туулай жилийн сар шинийн босгон дээр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн тушаалаар

цол нэмсэн цэргийн алба хаагчдад албан тушаалын зэрэглэлийн цол гардуулах ажиллагаа ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааны үеэр



ЭЛЭГ БҮТЭН АМЬДРАХ САЙХАН Хандивын аян

Зэвсэгт хүчний 353-р ангийн Ахлагч П.Уламбаатар миний охин У. Анударь нь төрөлхийн тархины усжилттай бөгөөд зүүн тархины 70% нь усжилттай. 24 цагийн 16 орчим цаг нь ганцаараа инээж таталт өгдөг учир мөрдөст нэг алба хаагч нар болон монголын халуун сэтгэлт ард түмнээсээ охинд минь амьдрал бэлэглээч гэж ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ хүсч байна.

Эмчлэх үлсын "New Delhi Akashi" эмнэлэгт эмчилгээ хийлгэвэл 100% өвчлөх боломжтой

Хандивын данс: Ээж Б.Чандалсүрэн 5039314462

Ахлагч П.Уламбаатарын охин Анударийн эмчилгээний зардалд Зэвсэгт хүчний 353 ангийн хамт олныхон зүгээс 6,000,000 төгрөгийг

сэтгэлийн хандивыг өргөж хурдан эдгэрч эрүүл, саруул болохын ерөөлийг дэвшүүлжээ.

Гэрэл зураг-нэг агшин



Шүүдэн ирлээ

Монгол цэргийн музейн сан хөмрөгөөс...